



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/449

Улаанбаатар хот

「 Хан-Уул дүүргийн 15 дугаар сургуулийн  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 427,500.0 /дөрвөн зуун хорин долоон мянга таван зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 15 дугаар сургууль /Ө.Шүрэнцэцэг/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн нийт 427,500.0 /дөрвөн зуун хорин долоон мянга таван зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 15 дугаар сургууль /Ө.Шүрэнцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.РЭНЦЭНБЯМБА

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2020 оны 09 дугаар сарын 04 өдрийн  
..... А/450..... дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Байгаль орчны газар

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил /нас/	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	ЭБХХХК-ын хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж							
1	Минж/ХБНГУ- эр/	4	ш	4	1,881,959	7,527,836.00	байгальд нутагшуулах
2	Минж/ХБНГУ- эр/	6	ш	1	1,881,959	1,881,959.00	байгальд нутагшуулах
3	Минж/ХБНГУ- эр/	5	ш	2	1,881,959	3,763,918.00	байгальд нутагшуулах
4	Минж/ХБНГУ- эр/	3	ш	3	1,881,959	5,645,877.00	байгальд нутагшуулах
5	Минж/ХБНГУ- эм/	4	ш	1	1,881,959	1,881,959.00	байгальд нутагшуулах
6	Минж/ОХУ эм/	5	ш	1	6,900,695	6,900,695.00	байгальд нутагшуулах
7	Минж/ХБНГУ-эм/	4	ш	2	1,881,959	3,763,918.00	байгальд нутагшуулах
8	Минж/ОХУ- эм/	4	ш	2	6,900,695	13,801,390.00	байгальд нутагшуулах
9	Минж/ОХУ-эр/	4	ш	1	6,379,457	6,379,457.34	байгальд нутагшуулах
				17		51,547,009.34	
Үүнээс:Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн							
Актлах хөрөнгийн дүн						<b>51,547,009.34</b>	